



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/717

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалтууд, Эрүүл мэндийн тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Зооноз өвчин судлалын төвийн хээрийн лабораторийн судалгаа, шинжилгээ, халдвар хамгааллын үйл ажиллагаанд шаардлагатай багаж, хамгаалах хэрэгсэл авахад шаардлагатай 2 764 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Зардалд шаардагдах 2 764 000 төгрөг /хоёр сая долоон зуун жаран дөрвөн мянган/ -ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.12 дахь заалтын "Эрүүл мэндийн эрсдлийг бууруулах" төсөл, хөтөлбөрийн зардлаас тооцож олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ч.Уранчимэг/-д хариуцуулсугай.


ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/717-Ch
03507

Аймгийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр
сарын 05-ны өдрийн А/717 дугаар
захирамжийн хавсралт



ЗООНОЗ ӨВЧИН СУДЛАЛЫН ХЭЭРИЙН ЛАБОРАТОРЫН СУДАЛГАА,
ШИНЖИЛГЭЭ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДЛАГАТАЙ ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ

№	Зардлын товч утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /мян төг/	Нийт үнэ /мян төг/
1	Халдвар хамгааллын нэг удаагийн өмсгөл	100	4000	400 000
2	1-р зэргийн хамгаалах өмсгөл	15	130 000	1950 000
3	Зайнаас халуун хэмжигч	3	138 000	414 000
НИЙТ ДҮН				2764 000

.....ооо.....